

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 12 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.12.20

Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл:

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголыг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хэлэлцэн батлав. Уг төлөвлөгөөний тодотголыг “Лапланд-Эко” ХХК гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн. Мөн Шивээговь сумын ИТХ нь 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Баянтал, Сүмбэр сумдуудын ИТХурал 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд хуралдаж “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-г тус тус хэлэлцэн баталлаа.



Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор 2018 онд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг баталсан.

Аймгийн 2018 онд **93,18 га газрыг 809 иргэнд** гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх бөгөөд үүнийгсумаарангилбал:

- Шивээговьсум140 иргэнд27 гагазрыг;
- Сүмбэр сум 542 иргэнд 39,68 га газрыг;
- Баянтал сум 127 иргэнд 26,5 га газрыг тус тус өмчлүүлэхээр батлагдсан.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Атар газрыг тариалангийн газар болгох саналыг дэмжих тухай” тогтоолоор Сүмбэр сумын Уул худагт 10000 га газрыг тариалангийн газарт уламжлахаар шийдвэрлэв.

2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг ИТХ-аараа 2017 оны 12 дугаар сарын 18, 20-ны өдрүүдэд 3 сум дүгнүүлэн хангалттай үнэлэгдсэн байна.

Газрын төлбөрийн орлого:

Газрын төлбөрийн орлогоор 2017 онд 90 сая төгрөгийг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас 115,2 сая төгрөгийн төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 128%-н биелэлттэй байна. Төлөвлөгөө давж биелсэн нь өмнөх оны өр төлбөр барагдуулсан болон шинээр нэмэгдсэн газруудын төлбөр орсон болно.

- 366 иргэний сая төгрөг 4,531,117
- 83 аж ахуйн нэгж, байгууллагын 110,671,115 сая төгрөгийнмэдээллийг нэгбүрчлэн нэр, регистрээр гаргаж тулгалт хийжтатварын хэлтэст сар бүр хүргүүлэн ажиллаж байна.

Газар эзэмшигч, ашиглагч 51 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 64 нэгж талбарын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэж ажиллалаа.

Хот байгуулалт, оронсууц, нийтийнажахуй, чиглэлээр:

1.БХБЯам, JICA-н төсөлхамтранзохионбайгуулсан“Монгол улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн II-р үе шат” 5 дах удаагийн сургалтад БХБХэлтсийн дарга Б.Даваажаргал, газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Ганзориг нар 2017 оны 11 дүгээр сарын 20-ноос 24-ны хугацаанд хамрагдсан.Сургалтаар гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд “Нэгж талбарын өөрчлөн зохион байгуулалтыг төлөвлөх” сэдвээр дадлага ажил хийсэн.

2.“Ус-Ду”ОНӨААТҮГазрын зуухны барилгын өргөтгөлийн ажлын зургийн даалгаварыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэстэй хамтран боловсруулсан.

3.Баянтал сумын 2-р багийн төвийн барилгын зургийн даалгаварт зөвөлгөө өгч хамтран ажилласан.

Тайлан мэдээ:

1.Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн нийт 11 баримт бичгийн биелэлтийг гарган Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

2. Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, захиалагчийн техник хяналтын тайлан зэргийг гарган хүргүүлсэн.

3. 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар ашиглалтад орсон орон сууц, үнийн борлуулалт, ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг гарган БХТөвд хүргүүлсэн.

4. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар албан даалгаварын хэрэгжилтийн биелэлтийггарган ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн.

Орон нутаг хөгжил сангийн хөрөнгө оруулалтын дараах ажлуудад ашиглалтад хүлээн авах комисст оролцсон.Үүнд:

1. Баянтал сумын 152-р байрны гадна “Тоглоомын талбайн тохижилт”-ийн ажил
2. Сүмбэр сум, “Баян булгийн эгнээний тохижилт”-ын ажил
3. Сүмбэр сум, “Усан хангамжийг сайруулах /худаг барих засварлах” ажил
4. Сүмбэр суманд “Айл өрхүүдийг хог хаягдал ангилан ялгах хогийн саваар хангах” ажил
5. Говьсүмбэр аймгийн “Төвийн хогийн цэгийг хашаажуулах” ажил

Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл дараах объектуудад олгосон байна.Үүнд:

1. Сүмбэр сум, “Ган бөмбөрцөг цогцолборын үйлдвэрийн барилга”-ын ажил
2. Сүмбэр сум, “Зуухны өргөтгөл”-ийн ажил
3. Сүмбэр сум, “100 хүүхдийн цэцэрлэгийн барилга”-ын ажил /Канад/
4. Сүмбэр сум,” Автозамын дагуух гэрэлтүүлэгийн толгой солих” ажил

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР